



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

Нийслэлийн Амгалан амаржих газрын
хөрөнгийг данснаас дансанд
шилжүүлэн бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 16,890,000 /арван зургаан сая найман зуун ерэн мянга/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Нийслэлийн Амгалан амаржих газар /Ц.Батболд/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Амгалан амаржих газар /Ц.Батболд/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

11501000407

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
 даргын 2020 оны 04 дүгээр сарын 22 ны өдрийн
 0/149 тоот тушаалын хавсралт



Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Амгалан амаржих газар

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
									нэгж үнэ	нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Нярай дулаацуулах ширээ	МК-90	220вт 50 60 гц	2016	12/28/2017	дунд	ш	1	5,900,000.00	5,900,000.00	1,474,999.00	4,425,001.00	Тавилга, эд хогшил	Тоног, төхөөрөмж
2	Индэр ком	Модон	Бор	2018	10/23/2018	сайн	ш	1	990,000.00	990,000.00	144,375.00	845,625.00	Тоног, төхөөрөмж	Тавилга, эд хогшил
3	Өвчтөний ор	Төмөр	Саарал	2016	1/2/2017	сайн	ш	4	2,500,000.00	10,000,000.00	6,000,000.00	4,000,000.00	Тоног, төхөөрөмж	Тавилга, эд хогшил
Машин, тоног төхөөрөмжийн нийт дүн								6		16,890,000.00	7,619,374.00	9,270,626.00		